



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1142

Шивээговь сум

Жүдо бөхийн зүүн бүсийн аварга шалгаруулах
тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны Монгол Улсын өсвөрийн улсын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээнд оролцох эрхийн төлөөх зүүн бүсийн аварга шалгаруулах сорилго барилдааныг Шивээговь сумын харьяа, жүдо бөхийн анхны дасгалжуулагч аймгийн арслан Лувсандоржийн Амаржаргал агсны нэрэмжит болгон суманд зохион байгуулсантай холбогдуулан жүдо бөхийг өсвөр үеийн хүүхэд, залуучуудад сурталчлан таниулж, улс болон аймгийн аваргыг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж ажилласан багш дасгалжуулагч, амжилт гаргасан тамирчдыг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.


2. Зүүн бүсийн өсвөр насны жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээний 53 жингийн 217 аваргаас, 73+ эрэгтэй, эмэгтэй тамирчдын шагналд 440,000 (дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулж, тамирчдыг шагнаж, урамшуулсугай.

3. Шивээговь сумын харьяа, жүдо бөхийн анхны дасгалжуулагч аймгийн арслан Лувсандоржийн Амаржаргал агсны гэр бүл, үр хүүхдэд хүндэтгэл үзүүлэх дурсгалын зүйлд 65,000 (жаран таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

4. Дээрх шагналд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

5. Арга хэмжээнд зарцуулагдах 673,000 (зургаан зуун далан гурван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д зөвшөөрсүгэй.

6. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч, нярав нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа) нарт тус тус үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2022 оны 04-р
сарын 08-ны өдрийн 11чд дугаар
захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨСӨВ

2022.04.09

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Засаг даргын "Жуух бичиг"				
1	Мөнгөн шагнал	4	30,000	120,000
2	Өргөмжлөл	4	12,000	48,000
Нийт				168,000
73+ эрэгтэй, эмэгтэй тамирчдын шагнал				
1	Эрэгтэй, эмэгтэй 1-р байр	2	55,000	110,000
2	Эрэгтэй, эмэгтэй 2-р байр	2	35,000	70,000
3	Эрэгтэй, эмэгтэй 3-р байр	4	25,000	100,000
4	Медаль /алт, мөнгө хүрэл/	8	20,000	160,000
Нийт				440,000
1	Гэр бүлд нь хүндэтгэл үзүүлэх			65,000
Нийт				673,000